

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭЗЭМШИЛТ,
АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 66 дугаар зүйлийн 66.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 64 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, тус газрын даргын баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалт, газар эзэмшилт, ашиглалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Э.Ганчимэг, Д.Сувдмаа, мэргэжилтэн Я.Эрдэнэбаатар нар системын шалгалт хийлээ.

Шалгалтаар тус байгууллагын төрийн өмчийн эд хөрөнгийн байдалтай газар дээр нь танилцаж төрийн өмчийн бүрэн бүтэн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээрийг хууль тогтоомжид заасны дагуу хадгалж, хамгаалж, эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байгаа эсэхийг шалгаж, хөрөнгийн бүртгэл хөтлөлт, тайлагналт, бүртгэлээр тавьж буй хяналт, түүний үр ашиг “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”- ээр хүлээсэн үүргийн биелэлтийг шалгаж дүгнэлт гаргав.

Шалгалтад хамрагдах хугацааны санхүүгийн баримтад дор дурдсан албан тушаалтан 1, 2 дугаар гарын үсгийг зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Д/д	Овог нэр	Албан тушаал	Эхэлсэн огноо	Дууссан огноо	Тушаал шийдвэр
Нэгдүгээр гарын үсэг зурсан албан тушаалтан					
1	Л.Мөнхзул	Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга	10/25/2023	9/8/2024	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023-10-25-ны өдрийн Б/34 дүгээр тушаал
2	Ц.Ганцэцэг	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	9/9/2024	Одоог хүртэл	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024-09-12-ны өдрийн Б/06 дугаар тушаал
Хоёрдугаар гарын үсэг зурсан албан тушаалтан					
1	П.Адьяасүрэн	Ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн	6/27/2024	Одоог хүртэл	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Б/211 тушаал, бүтцийн өөрчлөлтөөр 2024-06-27-ны өдрийн Б/155 дугаар тушаалаар томилогдсон

Нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Б/34 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар томилогдсон Л.Мөнхзул 2024 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл зурсан бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон Ц.Ганцэцэг 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл зуржээ.

Харин аппаратын мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах 2 дугаар гарын үсгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Б/211 тушаалаар томилогдсон, бүтцийн өөрчлөлтөөр даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Б/155 тушаалаар Захиргаа удирдлагын газрын үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогчоор томилогдсон П.Адъяасүрэн өнөөдрийг хүртэл зурж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн Төрийн аудитын байгууллага аудит хийж “Хязгаарлалттай дүгнэлт” өгсөн байна.

Аудиттай холбоотой нийт 637.1 сая төгрөгийн 15 зөрчил илэрч, 8.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 628.7 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага хүргүүлсэн алдаа зөрчил нь аудитын тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай дүгнэлт” өгөх үндэслэл болжээ.

Үндэсний аудитын газрын 2025.02.25-ны өдрийн 07/793 дугаар албан бичгээр хүргүүлсэн дүгнэлтэд хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна гэжээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Санхүүгийн үйл ажиллагаандаа Грийн финанс /Сангийн яамны зөвшөөрөлгүй/ санхүүгийн тайлангийн системийг ашиглаж байгаа бөгөөд энэхүү програм нь алдаатай, шаардлагатай мэдээллийг бүрэн, үнэн зөв, хүндрэлгүй татаж чадахгүй байгаагаас тээврийн хэрэгсэл дансны элэгдэл 17.9 сая төгрөгөөр дутуу тайлагнаж байгаа тул эрх бүхий, салбарын хувьд шаардлага хангасан компанийн программыг ашиглах шаардлагатай байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1.Нийгмийн даатгалын байгууллагын товч танилцуулга: Монгол оронд нийгмийн даатгалын тогтолцооны үндэс суурь нь нийгмийн хамгаалал, нийгмийн хангамж гэсэн утга агуулгын хүрээнд анх хэрэглэгдэн хөгжиж 1942 онд Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын дэргэд “Нийгмийн аюулаас хамгаалах хэлтэс” нэртэй алба байгуулагдсанаар тавигдсан бөгөөд 1960 оноос 1990 он хүртэл нийгмийн хангамж, нийгмийн даатгал гэсэн 2 дэд бүтэцтэйгээр хөгжиж иржээ.


Засгийн газраас 1990 онд нийгмийн хамгааллын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээ авч Хөдөлмөрийн яаманд Улсын нийгмийн хангамжийн газрыг байгуулж нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн нэгдсэн бодлого боловсруулах, даатгалын хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих, иргэдэд бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж олгох, асрамж, халамжийн үйлчилгээг хариуцах асуудал хамаарах болсон байна.

Нийгмийн даатгалын багц хуульд 2024 онд орсон нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийн өөрчлөлт, Засгийн газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хийсэн процессын дахин инженерчлэлийн дүгнэлт, зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоолоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийг “газар” болгож Нийслэлийн нийгмийн даатгалын газрыг татан буулгасантай холбогдуулан нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, орон тоо, нэршилд нэлээдгүй өөрчлөлт орсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаарыг батлах тухай” А/45 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын орон тооны дээд хязгаарыг 1485 байхаар тогтоож, мөн сайдын 2024 оны А/19, А/74 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталжээ.

Энэхүү шинэчлэгдсэн бүтцээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газар, 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн даатгалын газар, Мэдээлэл технологийн төв, БНСУ дахь нийгмийн даатгалын алба, Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нийт 35 хуулийн этгээдтэй байхаар батлагдсан байна.

Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо бүтцийн схем



Сайдын тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/53 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын, А/52 дугаар тушаалаар дүүргүүдийн Нийгмийн даатгалын газрын, А/51 дүгээр тушаалаар аймгуудын

Нийгмийн даатгалын газрын, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталжээ.

Нийгмийн даатгалын байгууллагын товч мэдээлэл

Нийгмийн даатгалын байгууллагын нэр	Хуулийн		Гэрчилгээн дэх үндсэн үйл ажиллагааны чиглэл, код	Орон тоо	
	гэрчил-гээтэй	гэрчил-гээгүй		батлагдсан	гүйцэтгэл
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл (ажлын алба)	1		НДҮЗ-ийн хуульд заасан эрх үүргийг хэрэгүүлэх /753000/, НДС-ийн орлого, зарлаг, ХО-ын гүйцэтгэлд хяналт тавих /671100/	12	12
Нийгмийн даатгалын ерөнхий газар	1		Нийгмийн даатгалын үйл ажиллагаа /8430/	93	86
Аймгийн Нийгмийн даатгалын газар	21		Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх	909	816
Дүүргийн Нийгмийн даатгалын газар	9		Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх	436	406
Мэдээлэл, технологийн төв	1		Нийгмийн даатгаллын салбарын мэдээллийн технологийн үйлчилгээ /753000/	19	16
БНСУ дахь ХНХ-ын үйлчилгээний төв	1		Нийгмийн хамгаалал, даатгалын үйлчилгээ /9609/	8	8
Эрүүл мэндийн магадлалын төв Зөвлөл		1		8	6
Маргаан хянан шийдвэрлэх Зөвлөл		1		8	8
Нийслэлийн нийгмийн даатгалын газар			Татан буугдаж, хаалтын баланс нь НДЕГ-ын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланд орсон.		
Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	1		НДЕГ-ын харьяанд шилжиж ирээгүй тул 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланд ороогүй.		
Нийт дүн	35	2	Маргаан хянан шийдвэрлэх Зөвлөл	1493	1358
	35+2=37		нь орон тооны мэдээнд орохгүй	1485	1350

Нийгмийн даатгалын /төв болон орон нутгийн байгууллага/ байгууллагын бүтцийг хуулийн этгээдийн гэрчилгээтэй 35 байгууллага болон 2 төвтэй нийт 37 нэгжтэй байхаар баталсан бөгөөд 2024 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлээрх дүнгээр шинэчлэн батлагдсан бүтцээр 35 хуулийн этгээдийн тайлан нэгтгэхээс татан буугдсан нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын хаалтын баланс нэгтгэлд орж тайлагнагдсан бол Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгийн тайлан нэгтгэгдээгүй байна.

Харин орон тооны дээд хязгаарыг 1485 байхаар батлагдсан бол нийт 35 хуулийн этгээд, 2 төвд /Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн орон тооны мэдээнд ордоггүй/ 1350 ажилтан албан хаагчтай ажилласан байна.

2.1.2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын товч танилцуулга: Нийгмийн даатгалын ерөнхий газар нь нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн удирдлагад ажиллаж бие даасан үйл ажиллагаа явуулж, болон хөдөлмөр, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудыг удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажилладаг байгууллага болно.

Тус газар нь 1942 оноос хойш олон удаа нэршил солигдож, 2016-2017 онд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар нэртэй байсан боловч Засгийн газрын 2017 оны “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болж одоог хүртэл энэ нэршилээрээ үйл ажиллагаа явуулж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц батлах тухай” А/25 дугаар тушаалаар бүтцийн өөрчлөлт хийгдсэн. Энэ бүтцээр Дотоод аудит, мониторингийн газар нь шинээр нэмэгдсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.02.07-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтцийг дахин шинэчлэн баталсан.

Засгийн газрын 2024.04.03-ны өдрийн 138 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооны хязгаарыг 82 гэснийг 93 гэж өөрчилсөн.

Эдгээр шийдвэрүүдийг үндэслэн бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/53 тушаалаар орон тооны хязгаарыг 93 албан хаагчтайгаар баталсан.


Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсан.

- Дотоод аудит, мониторингийн газар
- Захиргаа, удирдлагын газар
 - Хуулийн хэлтэс
 - Сургалтын хэлтэс
- Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газар
 - Судалгаа, актуар тооцооллын хэлтэс
- Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар
 - Олон нийттэй харилцах хэлтэс
- Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газар
- Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар
 - Тэтгэврийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хэлтэс
- Хяналт шалгалтын газар

Мөн сайдын А/19 дүгээр тушаалын 3 дахь заалтаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэд дор дурдсан төв, зөвлөл, алба, мэргэшлийн эмнэлгийг ажиллуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ✓ Мэдээллийн технологийн төв /16/
- ✓ Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл /6/
- ✓ Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл /7/
- ✓ Бүгд найрамдах Солонгос улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын алба /8/

Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтцийн схем



2.1.3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг үүрэг: Тус газар нь 2024

оноос нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах;
- ✓ Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулах, аймаг, нийслэлийн төсвийн нарийвчилсан хуваарийг батлах;
- ✓ Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд даатгуулагч, ажил олгогчид олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих;
- ✓ Тэтгэврийн нөөц сангийн орлогыг даатгуулагч бүрээр хуваарилж, байршуулах;
- ✓ Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
- ✓ Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах;
- ✓ Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, нийгмийн даатгалын байцаагч, ажилтныг тасралтгүй сургах, мэргэшүүлэх;
- ✓ Доод шатны байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

2.1.4.Хуулийн этгээдийн гэрчилгээ: Нийгмийн даатгалын ерөнхий газрыг 2006.11.06-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд 2021.06.15-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгож нэмэлт өөрчлөлтийг бүртгэсэн байна.

Хуулийн этгээдийн гэрчилгээнд тус агентлагын үйл ажиллагааны чиглэлийг Нийгмийн даатгалын үйл ажиллагаа /8430/, өөрийн хөрөнгийн хэмжээг 1,581,947.5 мянган төгрөг гэж тусгасан байна.

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Ц.Ганцэцэгийг томилсныг 2023.02.13-ны өдөр бүртгэсэн байна.

Шинэчлэн батлагдсан бүтцээр Мэдээллийн технологийн төв нэртэй батлагдсан байхад тус төвийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх мэдээлэл тооцоолол сургалтын төв нэртэй хэвээр буюу өөрчлөлт оруулж шинэчлээгүй байна.

ГУРАВ. ТӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭЗЭМШИЛТ, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт: Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийт хөрөнгө 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээр 5,392.95 сая төгрөг байна.

Санхүүгийн тайлангийн нийт актив хөрөнгийн 130.4 сая төгрөг буюу 2.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 5,262.6 сая төгрөг буюу 97.6 хувийг нь эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Нийт пассив хөрөнгийн 0.5 сая төгрөг буюу 0.01 хувийг өр төлбөр, 5,392.5 сая төгрөг буюу 99.99 хувийг нь эздийн өмч хөрөнгө эзэлж байна.

НДЕГ-ын 2024 оны санхүү байдлын тайлангийн үзүүлэлт /төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /2024.01.01/	Эцсийн үлдэгдэл /2024.12.31/	Хэлбэлзэл		Хувийн жин
			дүн	хувь	
Мөнгөн хөрөнгө	1,820,683	303,337	(1,517,346)	-83.3%	0.01%
Авлага	1,060,348	734,180	(326,168)	-30.8%	0.01%
Бараа материал	122,071,702	129,329,101	7,257,399	5.9%	2.40%
Эргэлтийн хөрөнгийн дүн	124,952,734	130,366,618	5,413,884	4.3%	2.42%
Биет хөрөнгө	5,252,028,683	5,202,304,393	(49,724,289)	-0.9%	96.46%
Биет бус хөрөнгө	96,152,481	60,279,744	(35,872,737)	-37.3%	1.12%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,348,181,164	5,262,584,137	(85,597,026)	-1.6%	97.58%
Нийт хөрөнгийн дүн	5,473,133,897	5,392,950,755	(80,183,142)	-1.5%	100.00%
Нийт өр төлбөр	1,793,452	454,086	(1,339,366)	-74.7%	0.01%
Засгийн газрын оруулсан капитал	2,130,919,958	2,130,919,958	-	0.0%	39.51%
Хуримтлагдсан үр дүн	1,652,793,695	1,573,949,920	(78,843,776)	-4.8%	29.19%
Өмнөх үеийн үр дүн	1,652,793,695	1,634,883,990	(17,909,705)	-1.1%	30.32%
Тайлант үеийн үр дүн	-	(60,934,071)	(60,934,071)	100.0%	-1.13%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,687,626,792	1,687,626,792	-	0.0%	31.29%
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,471,340,445	5,392,496,669	(78,843,776)	-1.4%	99.99%
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,473,133,897	5,392,950,755	(80,183,142)	-1.5%	100.00%

Нийт хөрөнгийн хэмжээ 2024 онд өмнөх оноосоо 80.2 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 80,2 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан бөгөөд бараа материалаас бусад бүх үзүүлэлтүүд буурсан дүнтэй байна.

Хэлбэлзлийг авч үзвэл эргэлтийн хөрөнгийн хэсэгт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл хамгийн өндөр буурсан үзүүлэлт байгаа бөгөөд 1,517.3 сая төгрөг буюу 83.3 хувиар, авлага 326.2 сая төгрөг буюу 30.8 хувь буурсан бол эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт биет бус хөрөнгө 35.9 сая төгрөг буюу 37.3 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Харин өр төлбөр 1.3 сая төгрөг буюу 74.4 хувиар буурсан цэвэр өмчийн дүн 78.8 сая төгрөг буюу 1.4 хувиар буурсан дүнтэй байгаа бөгөөд үүнд тайлант үед хуримтлагдсан элэгдлийг залруулж бүртгэсэн нь нөлөөлжээ.

Худалдан авалтын үйл ажиллагаа:

Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах зориулалтыг зааж, нийгмийн даатгалын байгууллагад үндсэн хөрөнгө бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэхгүй байгаа болон 2024 онд тус байгууллагад үндсэн хөрөнгө худалдан авах хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй байна. Иймд нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр хуулийн дагуу санхүүжүүлж зохион байгуулах нийт 145.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авалт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх 40.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий зардлын шинжтэй 1 худалдан авалтын төлөвлөгөөг батлан “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгуулж ажилласан байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /мян.төг/

№	Тендер шалгаруулалтын код[6]	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр[7], нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл (Бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ)	Төсөвт өртөг[8] (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ байгуулсан дүн (мян.төг)	Гэрээ байгуулсан этгээдийн нэр
Нийгмийн даатгалын сан								
1	НДЕГ/20240202009	Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн гарын авлага, тараах материал хэвлэх, эх бэлтгэх	Бараа	80,000,000	Харьцуулалтын арга	2024-06-26	58,960,000	Адмонпринт
2	НДЕГ/20240203008	Ажил олгогч, даатгуулагчдад зөвлөн туслах үйлчилгээний лавлах утас, цахим хариу үйлчилгээ.	Үйлчилгээ	65,000,000	Харьцуулалтын арга	2024-09-29	57,915,000	КоллПро
Дүн				145,000,000			116,875,000	
Урсгал төсөв								
3	НДЕГ/20240201005	Нийгмийн даатгалын ерөнхий газрын байрны харуул хамгаалалт	Үйлчилгээ	53,150,600	Харьцуулалтын арга			
4	НДЕГ/20240202004	Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай маягт	Бараа	40,000,000	Харьцуулалтын арга	2024-09-30	39,952,000	Адмонпринт
Дүн				93,150,600			39,952,000	

Худалдан авалтын төлөвлөгөөний дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж нийт 156.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан бол харуул хамгаалалтын тендер цуцлагдсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын байрны харуул хамгаалалтын ажил гүйцэтгүүлэх НДЕГ/202303045 дугаартай гэрээний хугацаа 2024.08.01-ний өдрийг хүртэл хүчинтэй байна.

Цаашид Сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.18-д “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тогтмол зардлаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг төлөвлөхгүй.” гэж заасны дагуу худалдан авах үйл ажиллагааг төлөвлөх, журмын дагуу худалдан авах үйл ажиллагааг тайлагнаж ажиллах нь зүйтэй.

3.2.Эргэлтийн бус хөрөнгийн дүн, бүтэц: Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээр 6,671.1 сая төгрөгийн балансын үнэтэй, 1,408.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 5,262.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй биет болон биет бус хөрөнгөтэй байна.

/Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц, үнэлгээ/

д/д	Эргэлтийн бус хөрөнгийн ангилал	Үлдэгдэл 2024-12-31, төгрөгөөр			Хөрөнгөд эзлэх хувийн жин		Элэгдлийн хувь, Балансын тооцооллоор
		Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Балансын үнэд	Үлдэгдэл үнэд	
1	Үндсэн хөрөнгө	6,475,400,020.54	1,273,095,627.10	5,202,304,393.44	97.1%	98.9%	19.7%
2	Биет бус хөрөнгө	195,723,304.60	135,443,560.70	60,279,743.90	2.9%	1.1%	69.2%
Нийт дүн		6,671,123,325.14	1,408,539,187.80	5,262,584,137.34	100.0%	100.0%	21.1%

Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв аппаратын санхүүгийн тайлангийн эргэлтийн бус хөрөнгө нь үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгөөс бүрдэж байгаагийн 97.1 хувийг үндсэн хөрөнгө, 2.9 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгөд шулуун шугамын аргаар элэгдэл тооцдог бөгөөд 2024 оны жилийн эцсийн тайлангаар 1.3 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулсан ба нийт хөрөнгөд 21.1 хувийн элэгдэл байгуулсан байна.

Элэгдлийн хувийг балансын тооцооллоор авч үзвэл үндсэн хөрөнгийн элэгдэл 19.7

хувьтай байгаа бол биет бус хөрөнгөд 69.2 хувийн хорогдол тооцсон байна.

3.3.Эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл, хорогдол: Нийгмийн даатгалын ерөнхий газрын эргэлтийн бус хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог ба 2024 оны жилийн эцсийн байдлаар биет хөрөнгийн элэгдэл 19.7 хувьтай, биет бус хөрөнгийн элэгдэл 69.2 хувьтай байна.

НДЕГ-ын эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл: /мян.төг/

Дансны нэр	Балансын өртөг /2024.12.31/	Хуримтлагдсан элэгдэл				Өөрчлөлт		Хувийн жин	Элэгдлийн хувь
		эхний үлдэгдэл /2024.01.01/	нэмж байгуулсан	хасагдсанд ногдох	эцсийн үлдэгдэл /2024.12.31/	дүн	хувь		
Барилга	5,014,828	394,315	70,751	-	465,066	70,751	17.9%	33.0%	9.3%
Нийтийн эзэмшил	17,116	8,151	1,433	-	9,584	1,433	17.6%	0.7%	56.0%
Авто тээврийн хэрэгсэл	89,520	10,380	109,506	79,808	40,077	29,697	286.1%	2.8%	44.8%
Машин, тоног төхөөрөмж	852,135	415,634	156,132	132,269	439,497	23,863	5.7%	31.2%	51.6%
Тавилга, эд хогшил	501,801	250,788	75,946	7,863	318,871	68,083	27.1%	22.6%	63.5%
Биет хөрөнгийн элэгдлийн дүн	6,475,400.0	1,079,268.3	413,767.6	219,940.3	1,273,096	193,827	18.0%	90.4%	19.7%
Программ хангамж	33,809	31,499	1,837	-	33,337	1,837	5.8%	2.4%	98.6%
Бусад биет бус хөрөнгө	102,107	68,071	34,036	-	102,107	34,036	50.0%	7.2%	100.0%
Газар эзэмших эрх	59,807	-	-	-	-	-	-	0.0%	0.0%
Биет бус хөрөнгийн элэгдлийн дүн	195,723.3	99,570.8	35,872.7	-	135,444	35,873	36.0%	9.6%	69.2%
Нийт дүн	6,671,123.3	1,178,839.1	449,640.3	219,940.3	1,408,539	229,700	19.5%	100%	21.1%

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлангийн дүнгээр үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 1,273.1 сая төгрөг байсан бол тайлант хугацаанд 449.6 сая төгрөгийн элэгдэл нэмж тооцон, хасагдсан хөрөнгөд ногдох болон залруулгаар 219.9 сая төгрөгийн элэгдэл хасагдаж жилийн эцсийн байдлаар 1,408.5 сая төгрөг буюу 21.1 хувийн хуримтлагдсан элэгдэлтэй байна.

Элэгдлийн хувь болон газар дээр нь танилцсан байдлаас харахад тус байгууллагын тавилга эд хогшил 63.5 хувийн элэгдэлтэй байгаа хэдий ч байгууллагын хувьд цаашид ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоон ашиглаж байгаа бол машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй компьютер техник хэрэгсэл нь технологийн хоцрогдолд орж, ажлын бүтээмжид нөлөөлөх хандлагатай байгааг анхаарах, үл хөдлөх хөрөнгийн элэгдэл хэдийгээр бага байгаа ч засвар үйлчилгээг хуулийн хүрээнд хийж төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж ажиллах нь зүйтэй.

Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн ч ашиглах боломжтой хөрөнгийн цаашид ашиглах жил, өртгийг жил бүрийн дотоодын тооллогын хүрээнд гаргаж шинэчлэн тогтоох, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан эд хөрөнгийн зохицуулалтын журмыг мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай.

3.4.Эргэлтийн бус хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт: Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүнгээр оны эхэнд 1910 тооны 6,527.0 сая төгрөгийн хөрөнгөтэй байсан бол жилийн эцсийн байдлаар 2113 тооны 6671.1 сая төгрөгийн балансын үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгөтэй болж 144.1 сая төгрөг буюу 2.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

НДЕГ-ын 2024 оны эргэлтийн бус хөрөнгийн дүн, хөдлөл өөрчлөлт /мян.төг/

Дансны нэр	Эхний үлдэгдэл /2024.01.01/		Нэмэгдсэн		Хасагдсан		Эцсийн үлдэгдэл /2024.12.31/		Өөрчлөлт		Хувийн жин
	тоо/х	дүн	тоо/х	дүн	тоо/х	дүн	тоо/х	дүн	дүн	хувь	
Барилга	5	5,014,828	0	-	0	-	5	5,014,828	-	0.0%	75.2%
Нийтийн эзэмшил	3	17,116	0	-	0	-	3	17,116	-	0.0%	0.3%
Авто тээврийн хэрэгсэл	2	62,070	3	111,750	2	84,300	3	89,520	27,450	44.2%	1.3%
Машин, тоног төхөөрөмж	740	807,713	231	189,143	149	144,721	822	852,135	44,422	5.5%	12.8%
Тавилга, эд хогшил	1098	429,570	153	84,399	33	12,168	1218	501,801	72,231	16.8%	7.5%
Биет хөрөнгийн балансын нийт дүн	1848	6,331,297	387	385,292	184	241,189	2,051	6,475,400	144,103	2.3%	97.1%
Программ хангамж	58	33,809	0	-	0	-	58	33,809	-	0.0%	0.5%
Бусад биет бус хөрөнгө	2	102,107	0	0	0	0	2	102,107	-	0.0%	1.5%
Газар эзэмших эрх	2	59,807					2	59,807	-	0.0%	0.9%
Биет бус хөрөнгийн балансын нийт дүн	62	195,723	-	-	-	-	62	195,723	-	0.0%	2.9%
Балансын нийт өртөг	1,910	6,527,020	387	385,292	184	241,189	2,113	6,671,123	144,103	2.2%	100.0%
Хуримтлагдсан элэгдэл		1,178,839						1,408,539	229,700	19.5%	21.1%
Үлдэгдэл өртөг		5,348,181						5,262,584	(85,597)	-1.6%	78.9%

Тус байгууллагын биет хөрөнгө нь оны эхэнд 1848 тооны 6,331.3 сая төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 387 тооны 385.3 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 184 тооны 241.2 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцсийн байдлаар 2051 тооны 6,475.4 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа бол биет бус хөрөнгийн хувьд нэмэгдсэн хасагдсан өөрчлөлт хийгдээгүй 62 тооны 195.8 сая төгрөгийн хөрөнгөтэй хэвээр байна.

Нэмэгдсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт нь тухайн жилд урсгал төсвөөс бэлтгэсэн, үнэ шинэчлэн тогтоосон хөрөнгийг орлого авсан, нийслэлийн нийгмийн даатгалын газар татан буугдсантай холбогдуулан балансаас балансад шилжиж ирсэн болон сайдын тушаалаар яамнаас шилжүүлсэн хөрөнгүүдтэй холбоотой байна.

Хасагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлт нь элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа шинэчлэн тогтоосон хөрөнгийн дүнг данснаас хассан, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй илүүдэлтэй хөрөнгийг салбар нэгж рүү балансаас балансад шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт эргэлтийн бус хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн дүнгээр балансын өртөг оны эхнээс 144.1 сая төгрөг буюу 2.2 хувь, хуримтлагдсан элэгдэл 229.7 сая төгрөг буюу 19.5 хувь тус тус нэмэгдэж, цэвэр дүн нь 85.6 сая төгрөг буюу 1.6% буурсан үзүүлэлттэй байна.

Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүнд биет ба биет бус хөрөнгийн эзлэх хувийн жинг дансны ангиллаар авч үзвэл 5.0 тэрбум төгрөг буюу 75.2 хувийг барилга байгууламж, 17.1 сая төгрөг буюу 0.3 хувийг нийтийн эзэмшлийн байгууламж, 89.5 сая төгрөг буюу 1.3 хувийг тээврийн хэрэгсэл, 852.1 сая төгрөг буюу 12.8 хувийг машин тоног төхөөрөмж, 501.8 сая төгрөг буюу 7.5 хувийг тавилга эд хогшил эзэлж байгаа бол 33.8 сая төгрөг буюу 0.5 хувийг програм хангамж, 102.1 сая төгрөг буюу 1.5 хувийг бусад биет бус хөрөнгө, 59.8 сая төгрөг буюу 0.9 хувийг газар эзэмших эрхийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Үүнээс харвал нийт эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх буюу 75.2 хувь нь 5 ширхэг барилга дансанд бүртгэлтэй хөрөнгө байна.

Биет бус хөрөнгө нийт эргэлтийн хөрөнгийн 1.1 хувийг эзэлж байгаагаас 58 ширхэг 33.8 сая төгрөгийн програм, 2 ширхэг 102.1 сая төгрөгийн цогц програм, лиценц, 59.8 сая төгрөгийн 2 ширхэг газар эзэмших эрх тус тус бүртгэлтэй байна.

3.5.Эргэлтийн бус хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн эрх зүйн байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг буюу Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” гэж заасан байна.

3.5.1.Нэмэгдсэн хөрөнгө: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлангийн дүнгээр нийт 387 ширхэг 385.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Нэмэгдсэн хөрөнгийн эрх зүйн үндэслэл /төгрөг/

Үндсэн хөрөнгө олж авсан хэлбэр	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Дансны нэр	Тоо, хэмжээ	Балансын үнэ	Хувийн жин
Худалдаж авсан	Урсгал төсөв /Багаж, техник, хэрэгсэл ангиллаас/	МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	27	24,114,390.0	6.8%
		ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ	6	1,958,470.0	
	Дүн		33	26,072,860.0	6.8%
Шилжүүлж авсан	УТХО ХНХЯ-ны сайдын 2024.06.27-ны А/134-р тушаал, НДЕГ-ын даргын 2024.09.11-ны А/152 тушаал	ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ	22	20,271,900.0	7.0%
	УТХО ХНХЯ-ны сайдын 2024.06.27-ны А/134-р тушаал, НДЕГ-ын даргын 2024.08.07-ны А/140 тушаал		12	6,604,176.0	
	МТТ-ийн зарлагын баримтаар, НДЕГ-ын 2024.10.02-ны А/167 тоот тушаал	МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	2	5,651,200.0	1.5%
	НДЕГ-ын 2024.10.02-ны А/166-р тушаалын 2-р хавралт /ННДГ-ын эргэлтийн хөрөнгөөс/		5	4,378,000.0	1.1%
	ХНХЯ-ны /төсөл/ 2024 оны 03/1489-албан бичиг		2	40,010,000.0	10.4%
	Дүн		43	76,915,276.0	20.0%
Бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж авсан	ТӨБЗГ 2024.08.23-ны 394-р тогтоол, НДЕГ-ын даргын 2024.10.02-ны А/166-р тушаалын 1-р хавсралт	АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	2	84,300,000.0	55.2%
		МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	77	73,365,741.5	
		ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ	112	55,017,100.0	
	Дүн		191	212,682,841.5	55.2%
Бусад буюу үнэ шинэчлэн тогтоож бүртгэсэн	ТӨБЗГ-ын 2025.01.09-ний 11-р тогтоол, НДЕГ-ын даргын 2025.01.15-ны өдрийн А/08 тоот тушаалын 1-р хавсралт	АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	1	27,450,000.0	18.1%
		МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	118	41,623,713.0	
		ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ	1	547,650.0	
	Дүн		120	69,621,363.0	18.1%
Нэмэгдсэн хөрөнгийн дүн			387	385,292,340.5	100%

1.Худалдаж авсан: Нийгмийн даатгалын ерөнхий газар /аппарат/-ын 2024 онд нийт нэмэгдсэн эргэлтийн бус хөрөнгийн 6.8 хувь нь урсгал төсвийн багаж техник хэрэгсэл зардлын эдийн засгийн ангилалд батлагдсан зардлаас худалдаж авсан 33 тооны 26.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил дансанд орлого авч бүртгэсэн хөрөнгүүд байна.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан: Нэмэгдсэн хөрөнгийн 7 хувь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/134 дүгээр тушаалаар шилжүүлж НДЕГ-ын даргын А/140 тушаалаар орлого авч нэмэгдсэн хөрөнгө байна.

Мөн нэмэгдсэн хөрөнгийн 1.1 хувь нь татан буугдсан Нийслэлийн нийгмийн даатгалын газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинжтэй 5 ширхэг 4.4 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж авах НДЕГ-ын даргын 2024 оны А/166 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан хөрөнгүүдийн дүнгээр нэмэгдсэн хөрөнгө байна.

Нэмэгдсэн нийт хөрөнгийн 10.4 хувь нь ХНХЯ-ны 2024 оны 03/1489 албан бичгээр

/төсөл/ шилжүүлсэн 40.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж авсан дүнгээр нэмэгдсэн хөрөнгө байна.

3.Төсвийн өөр шүүд захирагчийн урсгал төсвөөр үндсэн хөрөнгө бэлтгүүлж, өөрийн хөрөнгөд бүртгүүлсэн: Нэмэгдсэн нийт хөрөнгийн 1.5 хувь нь НДЕГ-ын 2024 оны 01/663 албан бичгээр хүргүүлсэн 1 ширхэг компьютер олгож өгөх хүсэлт болон бусад нэгжийн санал хүсэлтийн дагуу Мэдээлэл технологийн төвийн урсгал төсвийн санхүүжилтээр үндсэн хөрөнгө бэлтгүүлсэн бөгөөд НДЕГ-ын дарга 2024 оны А/167 дугаар тушаал гаргаж хөрөнгүүдийг хуваарилсан шийдвэрийн дагуу тус төвийн 2024.04.05-ны өдрийн 280253159 дугаартай зарлагын баримтаар шилжүүлсэн 5,651,200.0 төгрөгийн компьютер, дэлгэц гэсэн 2 ширхэг хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж нэмэгдсэн хөрөнгө байна.

4.Бусад буюу үнэ шинэчлэн тогтоож бүртгэсэн: Нэмэгдсэн нийт хөрөнгийн 18.1 хувь буюу 69,621,363.0 төгрөгийн хөрөнгө нь элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, ТӨБЗГ-ын 2025 оны 11 дүгээр тогтоол, НДЕГ-ын 2025 оны 1 дүгээр сарын 09-ний А/08 дугаар тушаалын дагуу орлого авч нэмэгдсэн хөрөнгө байна.

5.Бүтцийн өөрчлөлтөөр балансаас балансад шилжүүлж авсан: Нэмэгдсэн нийт хөрөнгийн 55.2 хувь буюу 212,682,841.5 төгрөгийн хөрөнгө нь Нийслэлийн нийгмийн даатгалыг татан буулгасантай холбогдуулан ТӨБЗГ-ын 2024 оны 394 дүгээр тогтоол, НДЕГ-ын 2024.10.02-ны А/166 тушаалын 1-р хавсралтын дагуу шилжиж ирсэн хөрөнгө байна.

3.5.2.Хасагдсан хөрөнгө: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлангийн дүнгээр нийт 184 ширхэг 241.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Хасагдсан хөрөнгийн эрх зүйн үндэслэл /төгрөг/

Үндсэн хөрөнгө данснаас хассан хэлбэр	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Дансны нэр	Тоо, хэмжээ	Балансын үнэ /төгрөг/	Хувийн жин
Бусад буюу үнэ шинэчлэн тогтоож хассан	ТӨБЗГ-ын 2025.01.09-ний 11 тоот тогтоол, НДЕГ-ын даргын 2025.01.15-ны өдрийн А/08 тоот тушаалын 1-р хавсралт	АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	1	54,900,000.0	
		МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	118	104,059,282.4	
		ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ	1	1,825,500.0	
		Дүн	120	160,784,782.4	66.7%
Балансаас балансад шилжүүлсэн	ТӨБЗГ-ын 2024.12.30 А1/2456 албан бичиг, НДЕГ-ын даргын 2025.01.15-ны А/08 тоот тушаалын 2-р хавсралт	АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	1	29,400,000.0	
		МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	31	40,661,788.5	
		ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ	32	10,342,745.0	
		Дүн	64	80,404,533.5	33.3%
Хасагдсан хөрөнгийн дүн			184	241,189,315.9	100%

1.Ашиглалтын хугацааг сунгаж, үнэ шинэчлэгдсэн: Хасагдсан нийт хөрөнгийн 66.7 хувь болох 120 ширхэг 160.8 сая төгрөгийн хөрөнгө нь ТӨБЗГ-ын 2025.01.09-ний 11 тоот тогтоол, НДЕГ-ын даргын 2025.01.15-ны өдрийн А/08 тоот тушаалын 1-р хавсралтын дагуу данснаас хасагдсан байна.

2. Балансаас балансад шилжүүлсэн: Хасагдсан нийт хөрөнгийн 33.3 хувь болох 184 ширхэг 241.23 сая төгрөгийн хөрөнгө нь ТӨБЗГ-ын 2024.12.30 А1/2456 албан бичиг, НДЕГ-ын даргын 2025.01.15-ны А/08 тоот тушаалын 2-р хавсралтын дагуу данснаас хасагдсан байна.

Барилга байгууламжийн талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аппаратын санхүүгийн тайландаа 5.0 тэрбум төгрөгийн балансын үнэтэй, 0.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 4.5 тэрбум төгрөгийн үлдэгдэл үнэ бүхий 5 ширхэг барилга, 17.1 сая төгрөгийн 9.6 сая төгрөгийн балансын үнэтэй, хуримтлагдсан элэгдэлтэй, 7.5 сая төгрөгийн үлдэгдэл үнэ бүхий нийтийн эзэмшлийн хөрөнгийг бүртгэсэн байна.

/Барилга, байгууламжийн талаарх мэдээлэл, төгрөгөөр/

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	АОО	Норма- тивт хугацаа	Ашиг- лах жил	Балансын үнэ 2024-12-31	Хуримтлагдс ан элэгдэл 2024-12-31	Үлдэгдэл үнэ 2024-12-31	Хувийн жин- балансын үнэд
1	Конторын барилга	ЧД, 4-р хороо, Хуульчдын гудамж	2004	80	61	3,021,038,538.8	293,024,229.9	2,728,014,308.9	60.0%
2	Цахим архивын барилга	ЧД, 4-р хороо, Бага тойруу, ХНХЯ- ны байр	2013	80	70	1,980,056,460.4	165,004,705.0	1,815,051,755.5	39.3%
3	Харуулын байр	ЧД, 4-р хороо	2004	20	10	1,156,680.0	684,369.0	472,311.0	0.02%
4	Аж ахуйн агуулах	СХД, 10-р хороо	2013	30	4	3,220,486.5	894,579.6	2,325,906.9	0.1%
5	Аж ахуйн харуулын байр	СХД, 10-р хороо	2013	20	10	9,356,256.0	5,457,816.0	3,898,440.0	0.2%
	Барилга байгууламжийн дүн:					5,014,828,421.8	465,065,699.5	4,549,762,722.3	99.7%
1	Зогсоол, тавцан-Бетон хучилттай автомашинь зогсоол	ЧД, 4-р хороо, Хуульчдын гудамж	2004	13	12	9,538,855.0	4,703,185.5	4,835,669.5	0.2%
2	Хашаа, саравч, сүүдрэвч-Тоосго, блок хашаа	СХД, 10-р хороо	2013	25	7	5,134,634.4	4,278,862.0	855,772.4	0.1%
3	Төмөр хашаа	СХД, 10-р хороо	2013	25	24	2,442,640.3	602,178.7	1,840,461.7	0.0%
	Нийтийн эзэмшлийн байгууламжийн дүн:					17,116,129.8	9,584,226.2	7,531,903.6	0.3%
	НИЙТ ДҮН:					5,031,944,551.5	474,649,925.7	4,557,294,625.9	100.0%

Барилга, байгууламжийг байршил, зориулалтаар нь ангилвал 2 конторын барилга, 2 агуулахын байр, 1 харуулын нийт 5 барилгатай.


Барилгуудаас:

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд байрлах 7 давхар, 9 автомашины зогсоол бүхий конторын барилгыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан конторын зориулалтаар ашиглаж байна.



[illegible]

Gender	Percentage
Male	68%
Female	32%

[illegible]

99

5 барилгыг дахин үнэлснээс 4 барилгын үнэлгээ 1,019.7 сая төгрөгөөр өссөн бол 1 барилгын үнэлгээ 1,159.6 сая төгрөгөөр буурсан байна.

Үнэлгээ буурсан 1 барилгын хувьд 2013-2015 онд баригдаж ашиглалтад орсон, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр зарим хэсгийг санхүүжүүлсэн, 11 давхар цахим архивын барилгыг 3,309,750,000.0 сая төгрөгөөр баланстаа бүртгэсэн.

Барилгын 2, 6, 7, 10, 11 давхрууд, 3 автозогсоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газар эзэмшдэг талаар үнэлгээний тайланд тэмдэглэсэн ба 2018 оны хөрөнгийн дахин үнэлгээгээр барилгын талбайн хэмжээг 1764 м2-р тооцож, барилгын үнэлгээг 1,159,609,164.58 төгрөгөөр бууруулан бодит үнэ цэнийг 1,980,056,460.42 төгрөгөөр тогтоон санхүүгийн бүртгэлдээ тусгасан байна. Үнэлгээ буурсан шалтгааныг үнэлгээний тайланд тэмдэглээгүй байна.

2018 онд үнэлсэн барилга байгууламжийн хөрөнгөөс 3 гараашийн барилгыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр 2022-2023 онуудад акталж данснаас хассан ба 2024 оны жилийн эцсийн байдлаар 5 барилга, 3 нийтийн эзэмшлийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Мөн үнэлгээнд хамрагдсан 8 барилгаас 2022 он, 2023 онд СХД-ийн 10 дугаар хороонд байрлах, 16,102,432.5 төгрөгийн балансын үнэ бүхий аж ахуйн агуулахын барилгын үнийг 3,320,486.5 төгрөгөөр дахин үнэлж үнэлгээг шинэчлэн тогтоосон байна.

/2018 оны дахин үнэлгээ хийсэн үл хөдлөх хөрөнгө, төгрөгөөр/

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	АОО	Нормативт хугацаа	Ашиглах жил	Үнэлэхээс өмнөх 2018-12-31			Үнэлсэний дараах балансын үнэ 2018-12-31	Дахин үнэлгээний өсөлт, бууралт
						Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ		
1	Конторын барилга	ЧД, 4-р хороо, Хуульчдын гудамж	2004	80	61	2,461,046,340.8	445,667,653.1	2,015,378,687.7	3,021,038,538.8	1,005,659,851.2
2	Цахим архивын барилга	ЧД, 4-р хороо, Бага тойруу, ХНХЯ-ны байр	2013	80	70	3,309,750,000.0	170,084,375.0	3,139,665,625.0	1,980,056,460.4	-1,159,609,164.6
3	Харуулын байр	ЧД, 4-р хороо	2004	20	10	1,650,000.0	1,430,000.0	220,000.0	1,156,680.0	936,680.0
4	Аж ахуйн агуулах	СХД, 10-р хороо	2013	30	4	12,300,000.0	4,441,666.7	7,858,333.3	16,102,432.5	8,244,099.2
5	Аж ахуйн харуулын байр	СХД, 10-р хороо	2013	20	10	7,000,000.0	2,527,777.8	4,472,222.2	9,356,256.0	4,884,033.8
Барилга байгууламжийн дүн:						5,791,746,340.8	624,151,472.5	5,167,594,868.2	5,027,710,367.8	-139,884,500.5
1	Зогсоол, тавцан-Бетон хучилттай автомашины зогсоол	ЧД, 4-р хороо, Хуульчдын гудамж	2004	13	12	7,630,000.0	4,844,444.4	2,785,555.6	9,538,855.0	6,753,299.4
2	Хашаа, саравч, сүүдрэвч-Тоосго, блокон хашаа	СХД, 10-р хороо	2013	25	7	10,200,000.0	8,783,333.3	1,416,666.7	5,134,634.4	3,717,967.8
3	Төмөр хашаа	СХД, 10-р хороо	2013	25	24	2,180,000.0	1,384,127.0	795,873.0	2,442,640.3	1,646,767.3
Нийтийн эзэмшлийн байгууламжийн дүн:						20,010,000.0	15,011,904.8	4,998,095.3	17,116,129.8	12,118,034.5
НИЙТ ДҮН:						5,811,756,340.8	639,163,377.3	5,172,592,963.5	5,044,826,497.5	-127,766,465.9
Үнэлгээ хийснээс хойш акталсан дүн:		3 ш гарааш				12,596,000.0	11,651,555.6	944,444.4	6,439,772.7	5,495,328.3
Нийт дүн:						5,822,462,340.8	648,924,932.9	5,173,537,407.9	5,051,266,270.2	-122,271,137.7

Үнэлгээний тайланд байгууллагын барилгад хамаарах дэд бүтцийн хөрөнгө болох дулааны болон цэвэр, бохир усны шугам, цахилгааны шугамыг тусад нь үнэлээгүй байна. Санхүүгийн ажилтнуудаас тодруулбал: Барилгад хамаарах дулааны болон цэвэр, бохир усны шугам, цахилгааны шугамуудыг конторын барилгын үнэлгээтэй нэгтгэн үнэлсэн гэдэг тайлбарыг өгсөн.

2018 оны Улсын нэгдсэн тооллогын баримтад барилга шугамын нийт хөрөнгийн дүнгээр татаж үзэхэд 2.2 тэрбум төгрөг болж, үнэлэхэд байсан балансын үнэ 2.4 тэрбум төгрөг буюу 258.6 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь өгсөн тайлбартай нийцэхгүй байна.

Иймд хөрөнгийн дахин үнэлгээний тайлангаар гарсан зөрүүг тодруулах, барилга

байгууламжид хамаарах дэд бүтцийн хөрөнгийн нэр төрлийг тодорхойлуулах, хэмжилтийг хийлгэх, үнэлгээг барилгын үнээс салгаж баланстаа бүртгэх замаар дахин үнэлгээний дүнд залруулга хийх шаардлагатай.

/НДЕГ-ын конторын барилгын 2018 оны тооллого, үнэлэхээс өмнөх дүнг харьцуулсан хүснэгт/

Д/д	Барилга байгууламжийн нэр	2018 оны тооллогын дүнгээр	Үнэлэхээс өмнөх балансын үнэ 2018-12-31	Зөрүү	Үнэлсэний дараах балансын үнэ	Тайлбар
1	Конторын барилга	2,064,850,860.8	2,461,046,340.8	258,550,085.0	3,021,038,538.8	Барилгын санхтехникийн хэсгийг 2019 оны дахин үнэлгээний тайланд тусад нь үнэлээгүй. Үнэлэхээс өмнөх дүн зөрүүтэй. Байгууллага санхтехникийн хэсгийг барилгын дүндээ нэмж үнэлүүлсэн гэсэн тайлбарыг өгсөн боловч 258.6 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
2	Дулааны шугам	32,130,000.0				
3	Цэвэр усны шугам	4,140,000.0				
4	Бохир усны шугам	310,000.0				
5	Гадна цахилгааны шугам	4,590,000.0				
6	Холбооны шугам	4,290,000.0				
7	Их засварын зургийн үнэ	6,159,888.0				
8	Конторын дээврийн их засвар	31,126,193.0				
9	Конторын дээврийн их засвар	54,899,314.0				
Нийт дүн:		2,202,496,255.8	2,461,046,340.8	258,550,085.0		

Төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтын байдлын талаар:


Нийгмийн даатгалын ерөнхий газрын барилга байгууламжид 2 конторын барилга, харуулын байр, Баянхошуунд аж ахуйн байр, агуулах зэрэг үл хөдлөх хөрөнгүүд бүртгэлтэй байна. Барилга байгууламжийн ашиглалтын байдлыг судлан үзвэл:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын байрлаж байгаа 7 давхар оффисын зориулалттай барилга: Барилгыг Нийгмийн даатгалын ерөнхий газар конторын зориулалтаар ашиглаж байна. Барилгын ашиглалт хэвийн, нэгж ажилтанд ногдох ажлын байрны ашигтай талбайг албан конторын зориулалттай өрөөний талбайд харьцуулан үзэхэд дунджаар 12.9 м2 талбай ногдож байгаа нь нэг албан хаагчид ногдох ажлын байрны нормтой нийцсэн байна.

/Конторын барилгын өрөөний тоо, талбай, албан хаагчийн судалгаа/

Барилгын давхрын дугаар	Албан хаагчийн тоо	Үүнээс:								Нийт барилгын өрөөний	
		Албан контор		Хурлын танхим, сургалт, лаборатори		Дулаан, цахилгаан, жижүүр, өлгүүр, архив, амрах өрөө, агуулах, НЭ-ийн бусад		Авто зогсоол			
		Тоо /ш/	Хэмжээ /м2/	Тоо /ш/	Хэмжээ /м2/	Тоо /ш/	Хэмжээ /м2/	Тоо /ш/	Хэмжээ /м2/	Тоо /ш/	Хэмжээ /м2/
1	15	1.00	79.11	2.00	73.05	11.00	113.58	-	78.43	14.00	344.17
2	18	7.00	251.86	-	-	5.00	91.30	-	-	12.00	343.16
3	17	9.00	218.92			8.00	121.29			17.00	340.21
4	18	12.00	233.50			8.00	103.56			20.00	337.06
5	11	13.00	234.67			5.00	93.70			18.00	328.37
6	19	4.00	130.68	1.00	22.20	7.00	189.47			12.00	342.35
7	0	2.00	117.50	1.00	139.50	6.00	110.80			9.00	367.80
Подвалын хэсэг	2					4.00	42.80		297.40	4.00	340.20
		48.0	1,266.2	4.0	234.8	54.0	866.5	-	375.8	106.0	2,743.3

Барилгын доод давхарт нийт 9 авто машины зогсоолтой бөгөөд 2 автомашины зогсоолыг дотоодын хэрэгцээндээ ашиглаж байна. 7 автомашины зогсоол нь ашиглалтгүй байна.



2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим архивын барилгын ашиглалтын талаар: 2014 онд ашиглалтад орсон, 11 давхар, зоорьтой оффисын барилга. Цахим архивын барилгын тал буюу төсөвт өртгийн 50 орчим хувиар тооцон балансдаа бүртгэсэн.

2018 оны дахин үнэлгээний тайланд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь барилгын 2, 6, 7, 10, 11 дүгээр давхруудыг буюу 5 давхрыг 3 автозогсоолыг эзэмшдэг гэж тэмдэглэгдсэн боловч албан ёсны гэрээ эрхийн актаар баталгаажуулаагүй байна.

Өнөөгийн байдлаар тус барилгын 6, 7 давхарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв нь үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 6 давхарт 6 өрөө, 7 давхарт 2 өрөө нийт 8 өрөөг оффис, серверийн өрөөний зориулалтаар ашиглаж байна.

3. Баянхошуунд байршилтай, аж ахуйн харуулын байрны ашиглалтын талаар:
Тус газрын балансад нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Баянхошуунд байршилтай газар дээр 2013 онд ашиглалтад орсон агуулах, харуулын байр зэрэг хөрөнгүүд байгаа боловч ашиглах боломжгүй болсон. 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан ХАГ 24/10 тоот гэрээний дагуу иргэн Г.Нэргүй хувийн өмчлөлийн эсгий гэрт амьдарч харуулын ажлыг гүйцэтгэдэг.





4. Төрийн өөрийн өмчийн байр талбайг түрээсээр ашиглуулсан талаар: Тус газар

нь төрийн өөрийн өмчийг бусдад ашиглуулснаас олсон орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дансандаа шууд төвлөрүүлдэг. 2024 онд төрийн өөрийн өмчийг түрээслүүлэн 55.7 сая төгрөгийн орлого олж, 22.3 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулан, сунгалтыг зохих журмын дагуу хийсэн байна.

/Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл/

Д/д	Түрээслүүлэгч	Түрээслэгчийн нэр	Түрээсийн байрны төрөл	Хэмжээ м2	Нэгж үнэ /төгрөг/	Хугацаа /сар/	Төлбөл зохих түрээсийн төлбөр	Төлөгдсөн дүн /төгрөг/	Үүнээс: Төсөвт төвлөрүүлсэн дүн
1	Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Ханбогд сум	Капитрон банк	Өрөө	72.63	12,000.00	12	10,458,720.00	10,458,720.00	4,183,488.00
2	Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Цогцэций сум	"Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ	Өрөө	56	12,000.00	12	8,064,000.00	8,064,000.00	3,225,600.00
3	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Төрийн банк	Өрөө	9.48	15,000.00	2	284,400.00	284,400.00	113,760.00
4	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Стандарт хэмжил зүйн хэлтэс	Өрөө	183.91	10,000.00	12	22,069,200.00	22,069,200.00	8,827,680.00
5	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	"Бодь даатгал" ХХК	Өрөө	6.25	16,000.00	12	1,200,000.00	1,200,000.00	480,000.00
6	Дархан-уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Төрийн банк	Өрөө	43	11,744.00	12	6,059,904.00	6,060,000.00	2,424,000.00
7	Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс-Замын үүд сум	Иргэн В.Оюун-эрдэнэ	Өрөө	95	6,000.00	2	1,140,000.00	1,140,000.00	456,000.00
8	Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар	Капитрон банк	Өрөө	10	20,000.00	3	600,000.00	600,000.00	240,000.00
9	Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар	Капитрон банк	Өрөө	38.5	20,000.00	6	4,620,000.00	4,620,000.00	1,848,000.00
				9.66		6	1,159,200.00	1,159,200.00	463,680.00
	Нийт дүн:						-	55,655,520.00	22,262,208.00

Тээврийн хэрэгслийн бүртгэл, чанар байдлын талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газрын баланст 2024 оны жилийн эцсийн тайлангаар нийт 3 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор төрийн байгууллагуудад ашиглах автомашины тоо төрөл тогтоосон байх бөгөөд энэхүү тогтоолд нийгмийн даатгалын ерөнхий газарт албан тушаалын автомашин унах эрх бүхий албан тушаалтан байхгүй байна. Иймд тус газар 3 ширхэг автомашинаа хөдөө ажлын болон дуулагын зориулалтаар ашигладаг байна.



2024 онд байгууллагын урсгал зардалд шатахууны зардлыг тусгаагүй тул байгууллагаас шатахуунтай холбоотой зардал гараагүй.

Тээврийн хэрэгслийн хадгалалт хамгаалалтын байдалтай газар дээр нь биет үзлэг хийхэд чанар байдлын хувьд дундаас доогуур, хувийн хэрэг хөтлөлт баяжуулалтыг журам, зааврын дагуу хөтөлж бүртгээгүй байна.

2024 онд Нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс татан буугдаж, 2 автомашиныг шилжүүлэн авсанаас үлдэх өртөггүй, Сонато маркийн, 1 тээврийн хэрэгслийг 27.5 сая төгрөгөөр үнэлж бүртгэсэн, 29.4 сая төгрөгийн балансын үнэтэй, Ланд круйзер маркийн 1 тээврийн хэрэгслийг Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтэст балансаас балансад шилжүүлсэн байна. Шилжүүлэн авсан Нийслэлийн нийгмийн даатгалын газрын нэр дээр бүртгэлтэй, Сонато УБҮ-08-68 дугаартай тээврийн хэрэгслийн өмчлөгчийн нэрийг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.

/Тээврийн хэрэгслийн үнэлгээ, хөдлөл өөрчлөлт, төгрөгөөр/

Д/д	Тээврийн хэрэгслийн			Анхны балансын үнэ /төгрөгөөр/	2024-01-01 Балансын үнэ	2024 онд		2024-12-31			Тайлбар
	Нэр, марк	Сери, Улсын дугаар	Үйлдвэр- лэсэн, АООН			Нэмэгдсэн	Хасагдсан	Балансын үнэ	Хуримтлаг- дсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	
1	Ланд круйзер-200 суудлын автомашин	УНУ, 06-98	2013, 7/18/2013	152,000,000	45,600,000	-	-	45,600,000	32,300,000	13,300,000	-
2	Сонато-LF суудлын автомашин	УБҮ, 04-29	2016, 4/29/2016	54,900,000	16,470,000	-	-	16,470,000	7,777,500	8,692,500	-
3	Суудлын автомашин,Hyund ai Sonata-LF,B,	УБҮ, 08-68	2014, 4/7/2017	54,900,000	-	54,900,000	54,900,000	27,450,000	-	27,450,000	Дахин үнэлж бүртгэлд тусгасан.
4	Ланд круйзер-200 суудлын автомашин	УНУ, 15-67	2011, 7/21/2017		0	29,400,000	29,400,000	-	-	-	Төв аймгийн НДХ-т шилжүүлсэн.
Нийт дүн:				261,800,000	62,070,000	111,750,000	84,300,000	89,520,000	40,077,500	49,442,500	

Эзэмшил газар, газрын үнэлгээ бүртгэлийн талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын газар эзэмших ашиглах эрхийн үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 2 нэгж талбарын 7613 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг 59,807,402.0 төгрөгөөр үнэлж дахин үнэлгээний дүнд хөндлөнгийн, хараат бус мэргэшсэн үнэлгээчин Д.Ганхуягаар нягтлан шалгалт хийлгүүлэн дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019-03-04-ны өдрийн 1/550 дугаартай албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн байна.

Байгууллагын эзэмших эрхийн газрыг үнэлж бүртгэснээс хойш дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

А. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэсвэрт байршилтай, аж ахуйн зориулалттай, эзэмших эрхийн 7048 м.кв газар дээр “Оргил рашаан сувилал” ХХК-ийн нэхэмжлэлтэй 2897 м.кв газрыг тус компанид давхцуулан олгосон талаар гаргасан нэхэмжлэлийн дагуу шүүх шалгаад:

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021-12-20-ны өдрийн 128/ШШ2021/0885 дугаартай шийдвэр гарч Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшиж байсан 7048 м.кв газраас нэхэмжлэгч “Оргил рашаан сувилал” ХХК-ийн эзэмшлийн 2639 м.кв газраас давхцуулан олгосныг хэсгийг хүчингүй болгох, мөн

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022-05-12-ны өдрийн 327 дугаар магадлалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хүлээн авах боломжгүй гэж үзсэнээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 онд үнэлж бүртгэсэн газраас 2739 м.кв газрыг хасаж Нийслэлийн засаг даргын 2023-06-05-ны өдрийн А/585 дугаар захирамжаар 4309 м.кв газрыг, 15 жилийн хугацаатайгаар, аж ахуйн зориулалтаар олгосон байна.

/Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмших ашиглах эрхийн газар/

Д/д	Газрын байршил	Газар эзэмшүүлэх шийдвэрийн огноо, дугаар	Зориулалт	Газрын хүчинтэй хугацаа /жил/	Газрын хэмжээ /м2/	Нэгжийн үнэлгээ /төгрөг/	Газрын үнэлгээ /төгрөгөөр/	Газар дээр байршиж буй хөрөнгийн нэр	Тайлбар
1	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Хуульчдын гудамж 13-01	2021-02-22-ны өдрийн НЗД-ийн А/105 дугаар захирамж	Контор	15	565	32,380	18,294,700.00	НДЕГ-ын конторын барилга	-
2	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Зүүн баян уул	2007-04-02-ны өдрийн, НЗД-ийн 131-дүгээр захирамж	Аж ахуйн	5	7048	—5,890	41,512,720.00	Агуулах, саравч, харуулын байр	Шүүхийн шийдвэрээр 2739 м.кв газар хасагдсан.Газрыг үнэлгээнд өөрчлөлт хийгдээгүй.
		2023-06-05-ны өдрийн, НЗД-ийн А/585 дүгээр захирамж	Аж ахуйн	15	4309	-	-	Агуулах, саравч, харуулын байр	
	Нийт дүн:				7613		59,807,420.00		

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай, аж ахуйн зориулалт бүхий 7048 м.кв газрыг 4.15 сая төгрөгөөр үнэлж санхүүгийн тайландаа тусгасан байсан.

2023 онд Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр 7048 м2 газраас 2739 м.кв-ийг “Оргил рашаан сувилал” ХХК-д шилжүүлэн өгч газрын хэмжээг 4309 м.кв болгон өөрчилсөн. Тус газар эзэмших эрхээ баталгаажуулсан боловч санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгө, дахин үнэлгээний дүнд залруулга хийж бүртгээгүй байна.

Б.2020 онд оффисын барилгын доорх 565 м.кв газарт газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтээр нийт 565 м.кв газар эзэмших зөвшөөрөлтэй. Үүнээс үйлчилгээний барилга 407.3 м.кв, автомашины зогсоол 205.9 м.кв талбайг эзэлж байна. Захирамжид зааснаас 49.6 м.кв талбайг зөвшөөрөлгүй буюу илүү ашигласан зөрчилтэй. Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.1, 35.3.5-д заасныг зөрчин зохих зөвшөөрөлгүй ашиглаж байгаа зөрчлийг арилгах, газрын гэрээнд заасны дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгах зэрэг зөвлөмжүүдийг өгсөн байна.

Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллого, баталгаажуулалт, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажил байдлын талаар:

Эд хөрөнгийн дотоодын тооллогын талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024.06.10-ны өдрийн А/98 дугаар тушаалаар 2024 оны эхний хагас жилийн өмч, үнэт цаас, аж ахуйн материалын тооллого явуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж 2022.06.06-06.27-ны өдрүүдэд тооллогыг хийж гүйцэтгэсэн байна. Эхний хагас жилийн дотоодын тооллогын илтгэх хуудсанд нийт 107.6 сая төгрөгийн бараа материл, 6,532.67 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгө тоологдсон тухай дурджээ. Тооллогыг хөрөнгө эзэмшигч бүрийн “Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын хуудас”-аар тулган тоолж нэмэгдэх, хасагдах хөрөнгийн судалгааг гаргасан байна.

Дуудлагын төвийн П.Эрдэнэбат, Т.Ариун-Эрдэнэ нарын эзэмшиж байгаа зөөврийн

РС-ийг хувьд нь өгсөн гэж ойлгосон тухай илтгэх хуудсанд дурдсан байгаа тул тухайн үед биетээр байхгүй байсан байна. Шалгалтын явцад тодруулж ажилласан.

Харин Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024.11.28-ны өдрийн А/215 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, аж аж ахуйн материал, маягтын тооллого явуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж 2023.11.27-12.13-ны өдрийн хугацаанд тооллогын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Эд хөрөнгийн тооллого явуулсан тухай илтгэх хуудсанд 5,262.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө 72.4 сая төгрөгийн бараа материал тоологдсон тухай дурдсан байна.

Тооллогын тайлангаар үндсэн хөрөнгийн ашиглалт, бүртгэлийг хөтөлж ашиглах хугацаа дууссан хөрөнгийн жагсаалт гарган тулгасан, шилжүүлэх, бүртгэх хөрөнгийн жагсаалт мөн актлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж тооллогыг зохион байгуулсан байна.



Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71,72,73 дахь заалтын дагуу дотоодын тооллогыг зохион байгуулах, 72 дахь заалтын дагуу тооллогын комисс эд хөрөнгийн чанар байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, үл хөдлөх хөрөнгийн засвар үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хийж насжилт, өмчийн өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, агуулахыг үлдэгдэл, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын

байдал, агуулахын эмх цэгц, хаягжилт, урьд оны тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг шалгаж, дутагдлыг арилгах гэх зэрэг арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй.

Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын талаар: ТӨБЗГ-ын 2022 оны 64-р тогтоолыг үндэслэн НДЕГ-ын даргын 2022 оны “Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” А/87 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогг удирдан зохион байгуулах Төв ажлын хэсэг, нийгмийн даатгалын ерөнхий газрын тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс/газар/-ын дарга нарт эд хөрөнгийн улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсэг томилох, заасн хугацаанд чанартай зохион байгуулж дүн тайланг бэлтгэн холбогдох газарт хүлээлгэн өгөх талаар үүрэг өгч хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, харьяа байгууллага, нэгж, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс/газар/-ын тооллогын материалыг авч нэгтгэн 7 нэгж /хавтас/ архивлан зохион байгуулалтын арга хэмжээг авч сайн ажилласан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар улсын үзлэг тооллогыг 2022.06.02-10-ны өдрүүдэд зохион байгуулж тооллогын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу хөтөлж баталгаажуулсан байна.

Тооллогын материалаас харахад аймаг, дүүргийн тооллогын маягт болон баримтын бүрдэл сайн байгаа бол ерөнхий газрын маягтын мэдээлэлд тавилга эд хогшил дансны хөрөнгийн ангиллын код, машин тоног төхөөрөмж дансны хөрөнгийн ангиллын код, марк, хүчин чадал, үйлдвэрлэсэн улс, огноо зэрэг нь цаасаарх материалд дутуу нөхөгдсөн байгаа нь өмчийн мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулаагүй, тооллогыг бүрэн хийж чадаагүй байна гэж үзэж байна.

Цаашид Нийгмийн даатгалын ерөнхий газар тооллогын ажлыг чанартай, үр дүнтэй бүрэн зохион байгуулж, хөрөнгийн чанар байдал, насжилт, элэгдэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд дүгнэлт өгч, тооллогын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг ханган, тайлагнаж ажиллах, нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд дүнг нэгтгэн дүгнэж байх шаардлагатай байна.

Дутагдсан: Биетээр байхгүй байгаа Хяналтын газрын дарга байсан Ганзориг өөрийн ашиглалтад байсан таблетыг ажлаас гарахдаа хүлээлгэн өгөөгүй байна.

Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/162 дугаар тушаалаар томилогдсон өмч хамгаалах Байнгын зөвлөлийг бүрэлдэхүүнийг 2024.11.04-ний А/190 тушаалаар дахин шинэчлэн баталсан байна.

Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн тайлан, ажлын баримттай танилцахад 2024 онд 3 удаа хуралдаж, зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, дүгнэлт гарган ажилласан, элэгдлээрээ өртгөө нөхсөн сэргээн засварлаж ашиглах боломжгүй 1565 ширхэг 3.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах, өртгөө бүрэн нөхсөн 1.545.3 сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийн үнийг 352.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож ашиглалтын хугацааг сунгах, 153 ширхэг 160.0 сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад балансаас балансаас шилжүүлэх асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргасан байна.

Зөвлөл нь салбарын хэмжээнд 10 ажил гүйцэтгэхээр төлөвлөж биелэлтийг тайлагнасан хэдий ч өмч хамгаалах Байнгын зөвлөлийн журамд заасан эрх үүргийн дагуу журмын хэрэгжилтийг хангах болон өөрийн хөрөнгийн өгөөж, үр ашгийг дээшлүүлэх талаар бодитой хийсэн ажлууд зөвлөлийн ажлын баримт болон тайланд

байхгүй байна.

Цаашид Өмч хамгаалах Байнгын зөвлөлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах талаар тушаалаар үүрэг өгч, энэхүү журмын дагуу ажлын төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэлийг хангаж ажиллах талаар зохих арга хэмжээ авах нь зүйтэй.

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газарт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” болон гэрээ сунгасан, дүгнэсэн баримт материал байхгүй байсан тул гэрээний үүргийн хэрэгжилт, дүгнэсэн үнэлгээ, илэрсэн зөрчил дутагдал, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээ гэх зэрэгтэй танилцаж үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

Төрийн өмчийг эзэмшигч тус байгууллага нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолын дагуу байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ны 6.2 дахь заалтад “Гэрээ нь хавсралт, холбогдох бичиг баримтын хамт ... Монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэж, тал тус бүр 1 (нэг) хувийг хадгална.” гэж заасныг зөрчиж баримтыг хадгалаагүй байгаа нь гэрээнд тавих хяналт, гэрээний эрх үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Эд хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний дагуу эзэмшиж, ашиглах үүрэгтэй.

2024 онд Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2023 оны дүнгээр 52 хувь буюу “Хангалтгүй” үнэлгээ авсан ба үнэлгээг хүлээн зөвшөөрч гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Гэрээний 1-р үзүүлэлт буюу “хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал” шалгуур үзүүлэлтээр 30 оноо авахаас 13 оноо, “Хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналын байдал” шалгуур үзүүлэлтээр 40 оноо авахаас 20 оноо, “Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн байдал” үзүүлэлтээр 10 оноос авахаас 7 оноо, Гэрээний харилцааг зохицуулах журмын хэрэгжилт, бэлтгэл хангасан байдал” үзүүлэлтээр 10 оноос авахаас 2 оноос авч 52 хувиар дүгнэгджээ.

Иймд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулж, гэрээний эрх үүргийн хэрэгжилт, баримтын бүрдлийг ханган ажиллах шаардлагатай байна.

Дотоод хяналт шалгалтын талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит мониторингийн газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалаар Дотоод аудитын газрын дарга 1, Аудитор-5 нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байсан боловч 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн тушаалаар Дотоод аудит, мониторингийн газрын дарга-1, Ахлах мэргэжилтэн-1, Мэргэжилтэн-4, нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тус газраас өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж төлөвлөгөөнд тусгасан 9 ажлыг хийж гүйцэтгэсэн гэж дүгнэсэн байна.

Үүнд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор

батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу Нийгмийн даатгалын байгууллагууд хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, актлах, бүртгэх ажлыг зохион байгуулж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны “Мэдээ, тайлан ирүүлэх тухай” А-1/340 дүгээр албан бичгээр ирүүлсэн зааврын дагуу Нийгмийн даатгалын байгууллагууд төрийн өмчийн бүртгэлийн burtgel.pcsp@gov.mn цахим системд 2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийг бүрэн бүртгэж, мэдээ, тайланг гарган, биелэлтийг хүргүүлсэн.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолыг үндэслэн Нийгмийн даатгалын газар болон тасгийн барилгыг нийт 8 аж ахуйн нэгжид түрээслэн “Төрийн өөрийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-ний 1.5-д заасны дагуу 54.5 сая төгрөгийн түрээсийн орлогыг төвлөрүүлсэн.
- Нийгмийн даатгалын байгууллагын хөрөнгийн бүртгэлд хэрэглэгдэх “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа”-г шинээр боловсруулан батлуулж нэгдсэн чиглэл заавар хүргүүлэн мөрдүүлж ажилласан.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/37 дугаар тушаалын дагуу Нийслэлийн нийгмийн даатгалын газрын эд хөрөнгөд хяналтын тооллого хийж, хөрөнгө хуваарилах ажлыг зохион байгуулсан.
- Нийгмийн даатгалын байгууллагуудын 30 тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөв.
- Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.
- Нийгмийн даатгалын ерөнхий даргын 2024 оны “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/190 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан бөгөөд зөвлөл нь байгууллагын тээврийн хэрэгсэл, барилга байгууламжийн засварын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
- Нийгмийн даатгалын салбарын үндсэн хөрөнгийн тооллого, тооцоог цахимжуулах зорилгоор бар код уншигч төхөөрөмж авахаар судалж, нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны төсвийн саналд тусгаж хүргүүлсэн.

ДӨРӨВ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ТАЛААР

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар баталсан Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөр тус агентлагын дэргэд “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг”-ийг ажиллуулахаар шийдвэрлэсэн ч өнөөдрийг хүртэл тушаалын хэрэгжилтийн хангаж, шилжүүлж аваагүй байна.
2. Шинэчлэн батлагдсан бүтцээр “Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээлэл тооцоолол сургалтын төв”-ийн нэрийг “Мэдээллийн технологийн төв” болгон өөрчилж баталсан ч тус төвийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчилж аваагүй байна.
3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2018 онд Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай, аж ахуйн зориулалт бүхий 7048 м.кв газрыг 4.15

сая төгрөгөөр үнэлж санхүүгийн тайландаа тусгасан ба газрын хэмжээнд 2023 онд 2739 м.кв-ийн хасагдах өөрчлөлт орсонг биет бус хөрөнгө, дахин үнэлгээний дүндээ залруулан бүртгээгүй байна.

4. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь санхүүгийн тайлангийн барилга байгууламжид хамаарах инженерийн байгууламжийг Сангийн сайдын баталсан 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын 3 дугаар хавсралтад заасны дагуу үнэлж бүртгэлд тусгаагүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 6, 7 дугаар хэсэгт заасныг зөрчин эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр 4 нэр төрлийн хөрөнгийг хөрөнгийн бүртгэлээс хассан байна.
5. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр бий болсон Цахим архивын барилгыг үндсэн хөрөнгөдөө бүртгэсэн боловч барилга болон автозогсоолоос өөрт ногдох хэсгийг гэрээ, эрхзүйн актаар баталгаажуулаагүй, өөрийн эзэмшлийн хэсгийг төрийн болон бусад байгууллагад ашиглуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 5 дахь хэсэгт “Төрийн өмчийн байранд төсөвт байгууллага, албан газар байрлах тохиолдолд өрөө тасалгааны түрээсийн төлбөрийг Улсын төсөвт тусгаснаар тооцно” гэж заасныг зөрчсөн байх бөгөөд өмч эзэмшлийн гэрээгээр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны жилийн эцсийн тайланд 3 ширхэг автомашин бүртгэлтэй байгаа боловч Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт автомашин тоо төрлөө тогтоолгоогүйгээс байгууллагын бүтцийн нэгжид жолоочийн ажлын байрны орон тоо тусгагдаагүй, урсгал төсвийн зардалд автомашины шатахууны зардал тавигдаагүй байна.
7. Тус газар нь Нийслэлийн нийгмийн даатгалын газрын нэр дээр бүртгэлтэй, Сонато УБҮ-08-68 дугаартай тээврийн хэрэгслийн үндсэн хөрөнгөдөө бүртгэсэн боловч өмчлөгчийн нэрийг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.
8. Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв аппарат нь барилга, байгууламжуудад хувийн хэргийн хөтлөлт бүрэн хийгдээгүй, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-т заасны дагуу барилга байгууламжийн үндсэн мэдээлэл, хийсэн үзлэг, шалгалт, их засвар, өргөтгөл, өөрчлөлт, дахин үнэлгээний мэдээлэл, шинэчлэлийн талаар болон барилга байгууламжид ашиглалтын явцад гарсан эвдрэл, гэмтэл, согогийн тухай болон төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор хийгдсэн ажлын талаарх мэдээллийг тухай бүр оруулаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газраас баталсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-д нийцүүлж, энэ журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг баяжуулж, хадгалах үүргийг тухайн барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч хүлээнэ гэж заасныг зөрчсөн байна.
9. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй, бие даасан хуулийн этгээд болох Мэдээлэл технологийн төвийн урсгал төсөвт төв, орон нутгийн салбарт нэн шаардлагатай компьютер, түүнийг дагалдах техник хэрэгсэл гэх мэт зарим хөрөнгийг худалдан авах төсвийг тусгаж, үндсэн хөрөнгө бэлтгүүлж иржээ. Өөр төсвийн шууд захирагчийн урсгал төсвөөс бэлтгүүлсэн 13,030,500.0 төгрөгийн 6 ширхэг техник хэрэгслийг НДЕГ-ын дарга 2024.10.02-ны өдрийн А/167 тоот тушаалаар салбаруудад хуваарилж бүртгүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1. “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж бүртгэн, тайлагнана.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл “Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх”-ийн 14.2.2 “улсын төсвөөс

олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах;”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 3.1, 5.1 дэх хэсэгт заасныг зөрчин эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр шилжүүлж авсан байна.

10. ТӨБЗГ-ын 2025.01.09-ний өдрийн 11-р тогтоол, НДЕГ-ын даргын 2025.01.15-ны өдрийн А/08 тоот тушаалын 1-р хавсралтад заасан 126 ширхэг 73,043,259.53 төгрөгийн шинэчлэн үнэ тогтоосон хөрөнгөөс 120 ширхэг 69,621,363 төгрөгийн хөрөнгийг бүртгэж, 6 ширхэг зөөврийн компьютерийн 3,421,896.58 төгрөгийн шинэчилсэн үнийг орлогод аваагүй буюу бүртгэлд дутуу тусгасан бол нөгөө талдаа 8,554,741.44 төгрөгийн балансын үнэтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг данснаас хасаагүй байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 4.1, 5.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
11. Мөн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024.06.27-ны А/134-р тушаал /УТХО/, НДЕГ-ын даргын 2024.09.11-ны А/152 тушаалаар хуваарилсан 6,688,000 төгрөгийн хурлын улаан хүрэн ширээ 8 сандлын хамт ком гэж зарлагын баримтат заасан хөрөнгийг 8 сандал гэж бүртгэсэн бөгөөд ком байсан хурлын улаан хүрэн ширээг салгаж бүртгэлд тусгаагүй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 5.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн байна.
12. ТӨБЗГ-ын 2024 оны А-1/2456 албан бичгээр балансаас балансад шилжүүлсэн 2025.01.09-ний өдрийн 11-р тогтоол 2,452,120 төгрөгийн 1 ш иж бүрэн 4524, Dell, Optiplex 3020 компьютерыг Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газарт шилжүүлж өгөөгүй байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 5.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн байна.

ТАВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

1. 2023 онд Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай, аж ахуйн зориулалт бүхий 7048 м.кв газрын хэмжээнд орсон 2739 м.кв-ийн хасагдах өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлдээ залруулан бүртгүүлэх талаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэн шийдвэрлүүлэх;
2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын оффисын зориулалтаар ашиглаж байгаа барилга байгууламжид хамаарах инженерийн байгууламжийн хөрөнгийн марк, тоо хэмжээ, нэр төрлийг тогтоон Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу үнэлэх, хөрөнгийн бүртгэлийг сэргээн баланстаа тусгах талаар санал боловсруулж эрх бүхий этгээдэд хүргүүлэн шийдвэрлүүлэх;
3. Санхүүгийн тайландаа бүртгэлтэй Цахим архивын барилгаас өөрт ногдох хэсгийг бүртгэл, гэрээгээр баталгаажуулах, эзэнжүүлэх, ашиглагч байгууллагуудын ашиглаж байгаа байр талбайн хэмжилт баталгаажуулалтыг хийж гэрээ байгуулах ажлыг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулах, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;
4. Тус байгууллага Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт автомашины тоо төрлөө тогтоолгох, шаардлагатай зардлыг төсөвт тусгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
5. Тус газар нь Нийслэлийн нийгмийн даатгалын газрын нэр дээр бүртгэлтэй, Сонато УБҮ-08-68 дугаартай тээврийн хэрэгслийн өмчлөгчийн нэрийг байгууллагын нэр дээр шилжүүлэх;
6. Барилга, байгууламжуудад хувийн хэргийн хөтлөлтийг Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-т заасны дагуу хөтлөх;

7. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн программ хангамжид шаардлагатай хөгжүүлэлт, нэмэлт өөрчлөлтийг хийлгэх хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах.
8. Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгө, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй бараа материалын шинжтэй хөрөнгийн дансны ангиллыг цэгцэлж бүртгэх;
9. Дотоодын тооллогыг ТБОНӨТ хуулийн 70, 71, 72-т заасны дагуу зохион байгуулж, тооллогын дүнгээр шийдвэрлэх асуудлын мөрөөр арга хэмжээ авч үр дүнг тайлагнаж ажиллах;
10. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах;
11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнаж байх;
12. Мэдээллийн технологийн төвийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, барагдуулах чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын төслийг танилцуулж байна.

Танилцаж зөвшөөрсөн:

Төрийн өмчийн хяналт шалгалтын
хэлтсийн дарга, Санхүүгийн хяналт
шалгалтын Улсын ахлах байцаагч
Ц.Түвшинзаяа

Тайлан боловсруулсан:

Төрийн өмчийн хяналт шалгалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн,
Санхүүгийн хяналт шалгалтын Улсын
ахлах байцаагч Д.Сувдмаа

Төрийн өмчийн хяналт шалгалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн,
Санхүүгийн хяналт шалгалтын Улсын
ахлах байцаагч Э.Ганчимэг

Төрийн өмчийн хяналт шалгалтын
хэлтсийн мэргэжилтэн
Я.Эрдэнэбаатар

Танилцаж зөвшөөрсөн:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
дарга Б.Батжаргал

Захиргаа удирдлагын газрын үйл
ажиллагаа хариуцсан ахлах нягтлан
бодогч Л.Нарантуяа